



АКПАР АУДИТ ХХК

“ЭРЧИМБАЯН-ӨЛГИЙ” ХК

**2019 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН
САНХҮҮГИЙН ТАЙЛАН**

АУДИТЫГ ДУУСГАВАР БОЛГОСОН ТУХАЙ ТАЙЛАН

ТАЙЛАНГ БЭЛТГЭСЭН:

“Акпар-Аудит” компанийн:

Ерөнхий захирал

Х.Баянбай

Аудитор

М.Хосбаяр

Чанарын хяналтын менежер

Д.Хишигсүрэн

Аудитын тайлантай холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 462131, 91919758 дугаарын утсаар харилцана уу

ХАЯГ:

Баянзүрх дүүрэг 6-р хороо,
“Гео төв”-ийн байр
407, 408, 409 тоот

Утас: 11- 462131, 91919758

E-mail: akpar.audit@gmail.com
bayanbai_havdan@yahoo.com

АГУУЛГА:

хуудас

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Аудитын дүгнэлт	2
Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл	3
Байгууллагын талаархи мэдээлэл	3
Материаллаг байдлын түвшин	3
Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	3
Тасралтгүй үйл ажиллагааны талаарх мэдээлэл	3
Балансын дараах үйл явдал	3
Аудит хийгдсэн Санхүүгийн байдлын тайлан	4
Аудит хийгдсэн Орлогын дэлгэрэнгүй тайлан	5
Аудит хийгдсэн Өмчийн өөрчлөлтийн тайлан	5
Аудит хийгдсэн Мөнгөн гүйлгээний тайлан	6

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

Мөнгөн хөрөнгө	7
Дансны авлага	7
Бусад авлага	8
Бараа материал	8
Үндсэн хөрөнгө	8
Үндсэн хөрөнгийн элэгдэл	8
Биет бус хөрөнгө, түүний хорогдол	9
Богино хугацаат өглөг	9
Урт хугацаат өглөг	10
Үйл ажиллагааны орлого	10
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	10
Аудитороос өгсөн зөвлөмж	10



**“ЭРЧИМБАЯН-ӨЛГИЙ”
КОМПАНИЙН УДИРДЛАГАД**

**Хараат бус аудиторын
тайлан**

Дүгнэлт

Бид Аудитын тухай хуулийн 9.1.1-д заасны дагуу “Эрчимбаян-өлгий” ХК-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан буюу Санхүүгийн байдлын тайлан, Орлогын дэлгэрэнгүй тайлан, Өмчийн өөрчлөлтийн тайлан, Мөнгөн гүйлгээний тайлан болон тайлангийн тодруулгуудаас бүрдсэн Санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар “Эрчимбаян-өлгий” ХК-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон бэлтгэсэн санхүүгийн тайлангууд нь Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС), Монгол Улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын Олон Улсын Стандарт (АОУС)-ын дагуу хийж гүйцэтгэсэн. АОУС-д заасан аудиторын хүлээх үүрэг, хариуцлагыг “Санхүүгийн тайлангийн аудитад аудиторын хүлээх үүрэг, хариуцлага” гэсэн хэсэгт тусгаж харуулав. Бид аудитын ажилд хамааралтай хараат бус байдлын болон ёс зүйн шаардлагуудыг бүрэн биелүүлж ажилласан. Бидний олж авсан баримт нотолгоонууд дээрх дүгнэлтийг гаргахад хангалттай, тохиромжтой гэж үзэж байна.

Санхүүгийн тайланд удирдлагын хүлээх үүрэг, хариуцлага

Санхүүгийн тайлангаа СТОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон түүнд нийцүүлэн гаргасан заавар журмын дагуу бэлтгэж, үнэн зөв толилуулах, нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг холбогдох стандарт, хуульд нийцүүлэн боловсруулан, тогтмол мөрдөж ажиллах нь байгууллагын удирдлагын үүрэг болно.

Мөн түүнчлэн хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, аюулгүй байдлыг хангах, хөрөнгийг янз бүрийн зальт ажиллагаанд өртүүлэхгүй байхаар дотоод хяналтын системийг бий болгох, байгууллагын үйл ажиллагааны болон нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурь, зарчмыг хангаж ажиллах нь байгууллагын удирдлагын хариуцлага юм.

Санхүүгийн тайлангийн аудитад аудиторын хүлээх үүрэг, хариуцлага

Аудиторын гол зорилго нь үйлчлүүлэгчийн санхүүгийн тайлангууд нь алдаа эсвэл залилангийн улмаас материаллаг буруу илэрхийллээс ангид эсэхэд дүгнэлт өгөхөд оршино. Тодорхой дүгнэлтэд хүрэхийн тулд АОУС-д нийцүүлэн боловсруулсан горимын дагуу шалгалт хийж, хангалттай, тохиромжтой баримт нотолгоо цуглуулах нь аудиторын үүрэг юм.

Аудитын горимуудыг батлагдсан төлөвлөгөөний дагуу аудитор өөрийн шийдлээр сонгох ба ирүүлсэн алдаа, зөрчил нь материаллаг буюу байгууллагын удирдлага болон хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх эсэхэд дүн шинжилгээ хийж, түүнд тохирсон дүгнэлт өгнө.

Аудитын шалгалтаар байнга алдаа зөрчил илрэх ёстой гэсэн ойлголт байж болохгүй бөгөөд бидний илрүүлсэн алдаа, зөрчил материаллаг бус бол түүнийг арилгуулах талаар тодорхой зөвлөгөө өгч ажиллана.

Цаасан болон цахим хэлбэрээр бэлтгэсэн аудитын ажлын баримтууд нь тус компанийн эмч бөгөөд аудиторын тайлан, зөвлөмжийн хамт 10 жил хадгална.



Х.БАЯНБАЙ

Огноо: 2020-03-12

Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг,
6-р хороо, Гео төвийн байр, 407, 409 тоот.
Утас: 976-11-462131, 976-91919758, 976-96969758.
И-мэйл: akpar.audit@gmail.com

Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл

Харилцан тохиролцож байгуулсан гэрээний дагуу “Эрчимбаян-Өлгий” компанийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Аудитыг “Аудитын тухай”, “Нягтлан бодох бүртгэлийн тухай”, “Компанийн тухай” хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн боловсруулсан дотоод горимын дагуу гүйцэтгэв.

Байгууллагын талаарх мэдээлэл

1	Байгууллагын нэр	" Эрчимбаян-Өлгий " ХК
2	Компанийн улсын бүртгэлийн дугаар	0210001004
3	Компанийн регистрийн дугаар	2003821
4	Үйл ажиллагааны чиглэл	Уур үйлдвэрлэл, халуун ус хангамж, цахилгаан үйлдвэрлэх, дамжуулах, ашигт малтмал ашиглах
5	Компанийн хаяг байршил	Баян-Өлгий аймаг, 4-р баг, Их булан 0.

Материаллаг байдлын түвшин

Материаллаг байдлын түвшинг тэвчиж болох хамгийн багаар буюу нийт зардлын 1.0 хувиар тогтооход 39.4 сая төгрөг байна.

Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх онд Акпар-Аудит ХХК аудит хийж хоёр зөвлөмж өгсний нэгийг нь биелүүлээгүй байна.

Тасралтгүй үйл ажиллагааны талаарх мэдээлэл

Ирээдүйд үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахад нөлөөлөх, эргэлзээ төрүүлэх нөхцөл байдал илрээгүй.

Балансын дараах үйл явдал

Балансын дараа онцгой зүйл илрээгүй.

АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

(Төгрөгөөр)

БАЛАНСЫН ЗҮЙЛ	2018 он	2019 он
1. ХӨРӨНГӨ		
1.1 Эргэлтийн хөрөнгө		
Мөнгөн хөрөнгө	58,923,500.00	21,839,831.10
Дансны авлага	585,737,000.00	1,941,442,807.80
Татвар, шимтгэлийн авлага	-	-
Бусад авлага	65,181,700.00	48,886,147.00
Бараа, материал	420,837,300.00	431,001,758.00
Урьдчилж төлсөн зардал, тооцоо	-	-
Эргэлтийн хөрөнгийн дүн	1,130,679,500.00	2,443,170,543.90
1.2 Эргэлтийн бус хөрөнгө		
Үндсэн хөрөнгө	1,365,817,200.00	1,265,013,050.00
Биет бус хөрөнгө	119,704,800.00	119,704,800.00
Дуусаагүй барилга, байгууламж	-	456,179,840.00
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	1,485,522,000.00	1,840,897,690.00
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	2,616,201,500.00	4,284,068,233.90
2. ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ		
2.1 Өр төлбөр		
Дансны өглөг	60,050,700.00	261,675,167.40
Татвар, шимтгэлийн өглөг	29,070,300.00	110,286,210.50
Цалингийн өглөг	-	-
Богино хугацаат зээл	2,310,000,000.00	720,000,000.00
Урьдчилж орсон орлого	-	-
Бусад богино хугацаат өр төлбөр	7,660,700.00	18,654,121.60
Богино хугацаат өр төлбөрийн дүн	2,406,781,700.00	1,110,615,499.50
Урт хугацаат зээл	-	3,291,000,000.00
Урт хугацаат өр төлбөр	-	-
Бусад урт хугацаат өр төлбөр	-	-
Урт хугацаат өр төлбөрийн дүн	-	3,291,000,000.00
Өр төлбөрийн нийт дүн	2,406,781,700.00	4,401,615,499.50
2.2 Эзэмшигчдийн өмч		
Хувийн өмч	53,617,700.00	53,617,700.00
Эзэмшигчдийн өмчийн бусад хэсэг		
Нэмж төлөгдсөн капитал		
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	349,564,200.00	-
Хуримтлагдсан ашиг, (алдагдал)	(193,762,100.00)	(171,164,965.60)
Тайлант үеийн	20,160,900.00	22,597,134.40
Өмнөх үеийн	(213,923,000.00)	(193,762,100.00)
Эзэмшигчдийн өмчийн дүн	209,419,800.00	(117,547,265.60)
ӨР ТӨЛБӨР, ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧИЙН ДҮН	2,616,201,500.00	4,284,068,233.90

Хавсралт тодруулгууд нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

АУДИТ ХИЙГДСЭН ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

(Төгрөгөөр)

ҮЗҮҮЛЭЛТ	2018 он	2019 он
Үндсэн үйл ажиллагааны орлого		
Борлуулалтын орлого	3,689,452,700.00	3,961,226,036.90
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	3,667,051,700.00	3,936,118,109.80
Нийт ашиг (алдагдал)	22,401,000.00	25,107,927.10
Үйл ажиллагааны зардал	-	-
Үйл ажиллагааны ашиг, (алдагдал)	22,401,000.00	25,107,927.10
Үндсэн бус үйл ажиллагааны орлого	-	-
Үндсэн бус үйл ажиллагааны зардал	-	-
Татвар төлөхийн өмнөх ашиг, (алдагдал)	22,401,000.00	25,107,927.10
Орлогын татварын зардал	2,240,100.00	2,510,792.70
Цэвэр ашиг, (алдагдал)	20,160,900.00	22,597,134.40

АУДИТ ХИЙГДСЭН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

(Төгрөгөөр)

ҮЗҮҮЛЭЛТ	Хувьцаат капитал	Хуримтлагдсан ашиг, (алдагдал)	Нийт дүн
2018 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	53,617,700.00	(193,762,100.00)	(140,144,400.00)
Бүртгэлийн бодлогын өөрчлөлт		-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз			-
Өмчид гарсан өөрчлөлт			-
Ногдол ашиг			-
Тайлант оны ашиг, (алдагдал)		22,597,134.40	22,597,134.40
2019 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	53,617,700.00	(171,164,965.60)	(117,547,265.60)

Хавсралт тодруулгууд нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

АУДИТ ХИЙГДСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

(Төгрөгөөр)

Үзүүлэлт	2018 он	2019 он
<i>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</i>		
Мөнгөн орлогын дүн	3,404,992,200.00	4,613,409,866.80
Борлуулалтын болон худалдан авагчдаас орсон мөнгө	3,404,992,200.00	4,613,409,866.80
Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	-	-
Бусад	-	-
Мөнгөн зарлагын дүн	3,667,051,700.00	3,936,118,109.78
Ажиллагсад олгосон мөнгө	538,184,700.00	575,834,701.00
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн мөнгө	81,164,200.00	113,935,210.00
Түүхий эд, материал худалдан авахад төлсөн мөнгө	769,652,100.00	622,827,823.78
Ашиглалтын зардалд төлсөн мөнгө	678,171,200.00	511,683,200.00
Түлш, шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэл	1,187,161,300.00	1,546,964,064.00
Төлсөн хүү	402,108,100.00	493,777,165.00
Татварын байгууллагад төлсөн	10,610,100.00	8,943,164.00
Бусад	-	62,152,782.00
Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(262,059,500.00)	677,291,757.02
<i>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</i>		
Мөнгөн орлогын дүн	289,816,200.00	-
Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	-	-
Бусдад олгосон зээл болон урьдчилгааны буцаан төлөлт	289,816,200.00	-
Мөнгөн зарлагын дүн	-	714,375,425.92
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	-
Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	-	714,375,425.92
Хөрөнгө оруулалтын цэвэр мөнгөн гүйлгээний дүн	289,816,200.00	(714,375,425.92)
<i>Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</i>		
Мөнгөн орлогын дүн	-	-
Зээл авсан	-	-
Хүүгийн орлого	-	-
Бусад	-	-
Мөнгөн зарлагын дүн	-	-
Зээл төлсөн	-	-
Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	-	-
Валютын ханшийн зөрүү	-	-
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээний дүн	-	-
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	27,756,700.00	(37,083,668.90)
Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл	31,166,800.00	58,923,500.00
Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл	58,923,500.00	21,839,831.10

Хавсралт тодруулгууд нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ТОДРУУЛГА

Санхүүгийн тайланд тусгагдсан хөрөнгө болон түүний эх үүсвэрийн үлдэгдэл дараах байдалтай байна. Үүнд:

Мөнгөн хөрөнгө

ХААН, Капитрон, Хас, Төрийн болон Голомт банкинд төгрөгийн харилцах данстай. Түргэн борлогдох үнэт цаас зэрэг мөнгөн хөрөнгөтэй адилтгах бусад хөрөнгө байхгүй байна.

ҮЗҮҮЛЭЛТ	Валютын төрөл	2018 он	2019 он
<i>Бэлэн мөнгө</i>			
Мөнгөн касс	MNT	105,470.00	-
Бэлэн мөнгөний дүн		105,470.00	-
ХААН банк	MNT	3,000,660.00	2,248,167.66
Голомт банк	MNT	55,816,830.00	5,667,525.00
Капитрон банк	MNT	540.00	4,154,780.00
Голомт банк	MNT	-	6,089,608.66
Хас банк	MNT	-	20,292.80
Төрийн банк	MNT	-	3,659,456.99
Банкин дахь мөнгийн дүн		58,818,030.00	21,839,831.11
Нийт мөнгөн хөрөнгийн дүн		58,923,500.00	21,839,831.11

Дансны авлага

Дансны авлага нь орлого гэж хүлээн зөвшөөрөгдсөн боловч хараахан хүлээж аваагүй байгаа бараа, үйлчилгээний үнэ болон бусад өр төлбөрөөс бүрддэг байна.

Авлагыг эцсийн дүнд цуглуулахаар тооцолж буй мөнгөн дүнгээр бүртгэдэг. Санхүүгийн тайланд нийт авлагаас найдваргүй авлагын нөөцийг хассан дүнгээр буюу цэвэр боломжит дүнгээр тусгадаг.

Тус компанийн хувьд харилцагчдаас авах авлагыг дансны авлагаар бүртгэсэн байна.

ҮЗҮҮЛЭЛТ	2018 он	2019 он
Нэгдсэн эмнэлэг	38,581,099.00	60,099,299.00
ОНС Музей	11,871,311.00	15,813,226.00
1-р ахлах сургууль	28,463,480.00	40,988,549.00
2-р ахлах сургууль	35,337,924.00	87,625,088.00
3-р ахлах сургууль	-	49,266,502.00
4-р ахлах сургууль	29,201,086.00	49,501,309.00
6-р ахлах сургууль	9,139,167.00	9,079,127.00
2-р цэцэрлэг	-	5,502,716.00
3-р цэцэрлэг	362,720.00	1,190,043.00
5-р цэцэрлэг	3,819,698.00	3,819,698.00
Ховд Их сургуулийн БӨ аймаг дахь салбар	277,417,329.00	359,868,136.00
Мэдээлэл холбооны сүлжээ	-	3,210,361.00
Аймгийн ЗДТГ	29,123,244.00	39,465,959.00
Радио нэвтрүүлэх станци	2,483,360.00	-
Спорт хороо	-	3,765,213.00
Суат ХХК	26,318,002.00	29,452,871.00

“Эрчимбаян-Өлгий” ХК-ийн 2019 оны санхүүгийн тайлангийн аудит

ХДТеатр	93,618,580.00	47,134,974.00
Байгууллагуудаас авах авлага	-	59,488,887.05
Гүлбахыг 2019 /айл өрх	-	41,920,813.00
Адилбек 2019 /айл өрх	-	37,348,823.63
Панар 2018 / айл өрх	-	27,531,713.12
Берик 4 ХХК	-	714,375,496.06
Өлгий цемент ХХК	-	254,994,003.94
Дансны авлагын нийт дүн	585,737,000.00	1,941,442,807.80

Бусад авлага

Бусад авлагаар ажилчин, албан хаагчдаас авах авлагыг бүртгэсэн байна.

ҮЗҮҮЛЭЛТ	2018 он	2019 он
ААХ-аас авах авлага	65,181,700.00	48,886,147.00
Нийт дүн	65,181,700.00	48,886,147.00

Бараа материал

Байгууллагын үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангах зорилгоор бэлтгэсэн сэлбэг хэрэгсэл, шатах тослох материал, бараа материал, нүүрс болон хөдөлмөр хамгааллын материалыг бараа материалын дансанд бүртгэсэн байна.

Бараа материалын үлдэгдэл дараах байдалтай байна.

ҮЗҮҮЛЭЛТ	2018 он	2019 он
Агуулахад байгаа бараа материал	420,837,300.00	365,381,249.00
Нүүрс	-	55,353,600.00
Шатах тослох материал	-	3,682,492.00
Хөдөлмөр хамгааллын материал	-	2,404,717.00
Бичиг хэргийн материал	-	813,200.00
Багаж хэрэгсэл	-	3,366,500.00
Бараа материалын дүн	420,837,300.00	431,001,758.00

Үндсэн хөрөнгө

Байгууллагын үйл ажиллагаанд зайлшгүй шаардлагатай үндсэн хөрөнгийг дараах байдлаар ангилан бүртгэсэн байна.

Хөрөнгийн ангилал	Оны эхний үлдэгдэл	Өөрчлөлт		Оны эцсийн үлдэгдэл
		нэмэгдсэн	хасагдсан	
Барилга байгууламж	1,444,605,500.00	211,989,252.00	57,473,600.00	1,599,121,152.00
Машин тоног төхөөрөмж	1,030,335,000.00	85,028,998.00	-	1,115,363,998.00
Тээврийн хэрэгсэл	422,500,000.00	-	172,500,000.00	250,000,000.00
Тавилга эд хогшил	112,779,500.00	1,499,900.00	-	114,279,400.00
Компьютер, дагалдах хэрэгсэл	6,550,000.00	1,550,000.00	-	8,100,000.00
Бусад үндсэн хөрөнгө	136,000,000.00	-	-	136,000,000.00
Үндсэн хөрөнгийн дүн	3,152,770,000.00	300,068,150.00	229,973,600.00	3,222,864,550.00

Үндсэн хөрөнгийн элэгдэл

“Эрчимбаян-Өлгий” ХК-ийн 2019 оны санхүүгийн тайлангийн аудит

Үндсэн хөрөнгийн элэгдлийг хөрөнгийн ашиглах хугацааг үндэслэн шулуун шугамын аргаар байгуулсан байна.

Хөрөнгийн ангилал	Оны эхний үлдэгдэл	Өөрчлөлт		Оны эцсийн үлдэгдэл
		нэмэгдсэн	хасагдсан	
Барилга байгууламж	983,313,000.00	80,941,200.00	-	1,064,254,200.00
Машин тоног төхөөрөмж	716,460,700.00	80,661,600.00	-	797,122,300.00
Тээврийн хэрэгсэл	70,644,100.00	7,433,300.00	-	78,077,400.00
Тавилга эд хогшил	15,025,100.00	1,512,100.00	-	16,537,200.00
Компьютер, дагалдах хэрэгсэл	1,509,900.00	350,500.00	-	1,860,400.00
Үндсэн хөрөнгийн элэгдлийн дүн	1,786,952,800.00	170,898,700.00	-	1,957,851,500.00
Үлдэгдэл өртөг	1,365,817,200.00			1,265,013,050.00

Биет бус хөрөнгө, түүний хорогдол

Тус дансанд тусгай зөвшөөрлийг бүртгэсэн байна.

Хөрөнгийн ангилал	Оны эхний үлдэгдэл	Өөрчлөлт		Оны эцсийн үлдэгдэл
		нэмэгдсэн	хасагдсан	
Бусад биет бус хөрөнгө	119,704,800.00	-	-	119,704,800.00
Биет бус хөрөнгийн дүн	119,704,800.00	-	-	119,704,800.00

Богино хугацаат өглөг

Богино хугацаат өглөгөөр харилцагч байгууллагад өгөх өглөг, хувь хүмүүст өгөх өглөг, цалингийн өглөг болон дутуу төлөгдсөн татвар, шимтгэлийг бүртгэсэн байна. Богино хугацаат зээлийн дансанд 2018 оны 4 дүгээр сарын 30-ны өдөр Голомт банкнаас авсан жилийн 20.4 хувийн хүүтэй, 5 жилийн хугацаатай, 2,000.0 сая төгрөгийн зээлийг бүртгэсэн байна.

ҮЗҮҮЛЭЛТ	2018 он	2019 он
<i>Дансны өглөг</i>		
ЦШС Газар	53,217,400.00	92,006,109.00
НИК ХХК	192,000.00	59,643,250.00
Эрчим хүчний зохицуулах хороо	-	14,587,000.00
Монголын цахилгаан холбооны газар	-	2,145.40
Тэс петролиум ХХК	6,641,300.00	-
Хувь хүмүүст өгөх өглөг	-	95,436,663.10
Дансны өглөгийн дүн	60,050,700.00	261,675,167.50
ХХОАТ-ын өр	7,660,700.00	14,557,319.70
ААОАТ-ын өр	840,500.00	6,041,574.60
НӨАТ-ын өр	28,229,800.00	18,441,581.90
НДШ-ийн өр	-	32,132,055.00
Суутгагчийн ХХОАТ-ын өр	-	18,654,121.60
Бусад татварын төлбөр	-	39,113,679.20
Татвар, шимтгэлийн өглөгийн дүн	36,731,000.00	128,940,332.00
Богино хугацаат зээл-Шугамын зээл	2,310,000,000.00	720,000,000.00
Богино хугацаат өр, төлбөрийн дүн	2,406,781,700.00	1,110,615,499.50

Урт хугацаат өглөг

Голомт банкнаас авсан зээлийн бүртгэсэн байна.

ҮЗҮҮЛЭЛТ	2018 он	2019 он
Банкны урт хугацаат зээл-Шугамын зээл	-	3,291,000,000.00
Урт хугацаат зээлийн дүн	-	3,291,000,000.00

2019 оны нийт орлого, зардал нь дараах байдалтай байна.

Үйл ажиллагааны орлого

ҮЗҮҮЛЭЛТ	2018 он	2019 он
Борлуулалтын орлого	3,689,452,700.00	3,961,226,036.90
Үйл ажиллагааны орлогын дүн	3,689,452,700.00	3,961,226,036.90

Борлуулсан бүтээгдэхүүний өртөг

ҮЗҮҮЛЭЛТ	2018 он	2019 он
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	3,667,051,700.00	3,936,118,109.80
Борлуулсан бүтээгдэхүүний өртгийн дүн	3,667,051,700.00	3,936,118,109.80

АУДИТОРУУДААС САНАЛ БОЛГОХ ЗӨВЛӨМЖ

Танай компанийн 2019 оны санхүүгийн тайланд аудит хийж дууссантай холбогдуулан дараах зөвлөмжийг өгч байна.

1. Санхүүгийн тайлан дахь татварын өглөгийн үлдэгдэл, татварын цахим систем дэх үлдэгдлээс зөрсөн байна. Татварын байгууллагатай тооцоо нийлж, зөрүүг арилгах.
2. Биет бус хөрөнгийн шинжтэй лицензийг үндсэн хөрөнгийн дансанд бүртгэсэн байна. Уг лицензийг биет бус хөрөнгөөр бүртгэж, ашиглах хугацааг үндэслэх хорогдуулах нь зүйтэй.
3. Байгууллагын Голомт, Хас болон Төрийн банкны харилцах дансуудын гүйлгээнүүдийг санхүүгийн тайлан болон татварын тайланд оруулалгүй үлдээсэн байна. Эдгээр дансуудын гүйлгээг дахин шалгаж шаардлагатай гэж үзвэл санхүү болон татварын тайланд засаж засвар оруулж мөн буруу зарцуулалт байгаа эсэхийг шалгах хэрэгтэй.



“АКПАР-АУДИТ” КОМПАНИ

Регистрийн дугаар:

2	0	0	3	8	2	1
---	---	---	---	---	---	---

Хаяг : Баян-Өлгий аймаг Өлгий сум 4-р баг

Шуудангийн хаяг : _____

Утас : 70422512

Факс : 70422512


Өмчийн хэлбэр : Төрийн хувь

хувийн 100 хувь.



**“ЭРЧИМБАЯН ӨЛГИЙ” ХК-ИЙН
 2019 ОНЫ ЖИЛИЙН
 САНХҮҮГИЙН ТАЙЛАН**



Хянаж хүлээн авсан байгууллагын нэр	Сар, өдөр	Гарын үсэг
СТ Сүхбаатар	2020.11.12	 Б.Оюундорж
Д.Клар Бүдэг ХХК	2020.05.12	